



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

31.54.ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогын дүнгээр илэрсэн бүртгэлгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн биелэлт 66.3 хувь, маргаантай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн биелэлт 37.9 хувь, дутагдуулсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн биелэлт 59.6 хувь, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн биелэлт 93.1 хувь болж Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоолын 1.9 дэх заалт 64.5 хувьтай биелсэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг тайлагнах;

2. Улсын үзлэг, тооллогын дүнгээрх бүртгэлгүй хөрөнгийг бүртгэх, дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэлтэй болон ашиглах боломжгүй болсон хөрөнгийг шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс болон Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн газарт тус тус даалгав” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132335322
31-r_huraldaan.docx